


**АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР
2026 ОНЫ I УЛИРАЛД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АЖЛЫН ТАЙЛАН МЭДЭЭ**

№	Үйл ажиллагааны чиглэл	Холбогдох нэгж	Хэрэгжилтийн тайлан
1	Хөдөлмөр эрхлэлтийн талаар хийж хэрэгжүүлсэн ажлууд	ЗУХ	-Компанийн бүтэц, орон тоонд өөрчлөлт орсонтой холбоотойгоор ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн батлуулсан. -Эхний улирлын байдлаар хөдөлмөрийн гэрээ байгуулан шинээр ажилд орсон 6 ажилтан байна. Мөн 2 ажилтан хүүхэд асрэх чөлөөнөөс ажилдаа орж үргэлжлүүлэн ажиллаж байна. Ажлаас гарсан нийт 3 ажилтан байгаагаас хөдөлмөрийн гэрээ дууссан-1, ажил олгогчийн санаачлагаар-1, өөрийн хүсэлтээр-1 ажилтан ажлаас гарсан байна.
2	Цалин хөлсний талаар хийж хэрэгжүүлсэн ажлууд	СБХ	Тайлант хугацаанд ажилтнуудын цалин хөлсийг тогтсон хугацаанд тогтмол олгож ажилласан бөгөөд ЭМ, НДШ-ийн тооцоог сар бүр хийж харьяа дүүрэгт хуулийн хугацаанд нь гарган баталгаажуулж ажилласан.
3	Ажилтнуудын мэргэжил боловсрол, сургалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлууд	ЗУХ	"БҮХ АЖИЛТНЫ ХУРАЛ"-ыг 2 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар 2025 оны үйл ажиллагааны тайлан мэдээ болон 2026 оны зорилго зорилтоо тодорхойлж, цех, нэгжүүд "БҮТЭЭЛЧ ДААЛГАВАР" хүлээн авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. -Нийт ажилтнуудад 2 дугаар сард Эрчим хүчний зохицуулах хорооноос Эрчим хүч хэмнэлт нөлөөллийн аяны хүрээнд сургалт мэдээлэл зохион байгуулагдсан. -ЭХҮТ ТӨХХК дээр Өндөр даралтын хаалт арматурын засварчны ахисан түвшний сургалтад 2 ажилтан хамрагдсан. -Герман Монгол мэргэжлийн боловсролын сургууль дээр 2 дугаар сард Цахилгаан гагнуурын сургалтад 1 ажилтан хамрагдсан -СХЗГ дээр 3 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд Хэмжилзүйн суурь асуудлууд сэдэвт сургалтад 2 ажилтан, хэмжилзүйн мэргэшүүлэх сургалтад 1 ажилтан хамрагдсан -Нийт ажилтнуудад 3 дугаар сард Гамшгаас хамгаалах тактик сургалтыг Гал унтраах 18 дугаар ангиас зохион зохион байгуулсан.

4	Ажилтнуудын нийгмийн асуудлын талаар хийж хэрэгжүүлсэн ажлууд	ЗУХ	-Журмын дагуу 16 ажилтанд орон сууц, хашаа байшин худалдаж авах, нөхцөл сайжруулад дэмжлэг үзүүлсэн. -Компанийн нийт ахмад настангуудад сар шинийн баярыг тохиолдуулан журмын дагуу хүндэтгэл үзүүлсэн. -Хууль журамд заасны дагуу ажилтнуудад холбогдох чөлөөг олгож ажилласан бөгөөд тухайн тайлант хугацаанд 7 ажилтанд шинээр төрсөн хүүхдээ асрахад зориулан эцгийн чөлөөг олгосон. -Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажилтнуудыг идэвхижүүлэх оролцоог хангах чиглэлээр эр цэргийн баяр, олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрүүдийн хүрээнд бие биедээ талархлын үгээ бичих аяныг нийт ажилтнуудын дунд өрнүүлж ажилласан.
5	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлууд	ХХ	-Тайлант хугацаанд ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнд тараг, сүү, аньс чацарганы өтгөрүүлсэн жүүс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болох аарц, үзэмний шүүс сонголтоор олгон ажиллаж байна. - 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар байгууллагын хэмжээнд хөдөлмөр хамгааллын I шатны үзлэгийг 67 удаа хийж 310 зөрчил илрүүлэн 310 зөрчлийг устгасан, II шатны үзлэгийг 59 удаа хийж 51 зөрчил илрүүлэн 51 зөрчлийг устгаж ажилласан. -Жил бүрийн 04 дүгээр сарыг дэлхий даяар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сар болгон тэмдэглэн өнгөрүүлдэгтэй холбогдуулан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн аян-2026” сэдэвт сарын аян зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ЗУХ-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Г.МӨНГӨНЦЭЦЭГ



Б.НЯМСҮРЭН